



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 08 өдөр

Дугаар A/303

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.10-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийг сонгон шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг нийслэл, аймгийн Онцгой байдлын газрын дарга нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

1425012557

D:\2025\3,4\tushaal 3,4-2025.docx

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 08 дугаар сарын 08-ний өдрийн
тушаалын хавсралт



ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН (АХЛАХ) БАЙЦААГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1.Энэ журмын зорилго нь гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, мэргэшсэн алба хаагчийн нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулахад оршино.

1.2.Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт явуулахад Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, Төрийн албаны салбар зөвлөлийн холбогдох дүрэм, журмыг удирдлага болгоно.

1.3.Сонгон шалгаруулалтын сургах, мэргэшүүлэх, томилох, дэвшүүлэх үйл ажиллагаанд хууль дээдлэх, ёс зүйтэй, ил тод, нээлттэй, авлига ашиг сонирхлоос ангид байх зарчмыг баримталж, шалгалтын үнэлгээ, материал, бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулж, хяналтын бичлэг хийх, оролцогч гомдол гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.Энэхүү журам нь Онцгой байдлын байгууллагад ажиллаж байгаа төрийн тусгай алба хаагчид хамаарна.

Хоёр. Сонгон шалгаруулалтын төрөл

2.1.Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийг дараах ангиллаар сонгон шалгаруулна: Үүнд:

2.1.1.Гал түймрийн улсын хяналтын байцаагч;

2.1.2.Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч;

Гурав. Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагч албан тушаалын нөөц бүрдүүлэх

3.1.Гал түймэртэй тэмцэх газар гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй офицеруудын судалгааг жил бүрийн 1 дүгээр улиралд нээлттэй хүлээн авч бүртгэнэ.

3.2.Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн сонгон шалгаруулалтыг Захиргаа, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж зохион байгуулна.

3.3.Гал түймрийн улсын хяналтын байцаагчаар 3-аас доошгүй жил ажилласан алба хаагчдаас жилд 2 удаа (хавар, намар) түвшин тогтоох шалгалтыг Гал түймэртэй тэмцэх газар зохион байгуулж, өндөр оноо авсан алба хаагчдыг гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн нөөцөд бүртгэнэ.

3.4.Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн нөөцийг бэлтгэгдсэн болон бэлтгэгдэж байгаа гэсэн 2 ангиллаар бүрдүүлнэ.

3.5.Бэлтгэгдсэн ангилалд дараах шаардлагыг бүрэн хангасан албан хаагчийг бүртгэнэ.

3.5.1.Журмын 3.7-д заасан нийтлэг шаардлагыг хангасан,

3.5.2.Журмын 4.3-д заасан шалгалтад 70-аас доошгүй оноо авсан,

3.5.3.Журмын 3.8-д заасан тусгай шаардлагыг хангасан.

3.6.Бэлтгэгдэж байгаа ангилалд дараах албан хаагчийг бүртгэнэ.

3.6.1.Дотоод, гадаадын цэргийн сургууль болон Онцгой байдлын байгууллагын захиалгаар бакалавр буюу түүнээс дээш боловсролын зэргээр суралцаж байгаа сонсогч, суралцагч,

3.6.2.Гал түймрийн улсын хяналтын байцаагчаар 3-аас доошгүй жил ажиллаж буй албан хаагчийг,

3.7.Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн нөөцөд бүртгэх албан хаагчийн нийтлэг шаардлага:

3.7.1.Мэргэшсэн,

3.7.2.Удирдан зохион байгуулах, манлайлах чадвартай,

3.7.3.Хамт олны дунд нэр хүндтэй

3.7.4.Бие хүний хувьд төлөвшсөн, хувийн соёлтой,

3.7.5.Харилцааны ур чадвартай

3.7.6.Хариуцлагатай төрийн алба хаагчийн ёс зүйг шаардлага хангасан байх,

3.7.7.Авлига, албан тушаал, хувийн ашиг сонирхлоос ангид, холбогдож байгаагүй.

3.7.8.Өөрийгөө хөгжүүлэх эрмэлзэлтэй.

3.8.Тусгай шаардлага:

3.8.1.Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн тусгай шаардлага: Дотоод, гадаадын их сургуулийг Онцгой байдал-гамшгаас хамгаалах алба болон холбогдох чиглэлийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн Онцгой байдлын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх;

3.8.2.Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчид: Онцгой байдал, гамшиг судлал мэргэжлээр магистрын зэрэгтэй Гал түймрийн улсын хяналтын байцаагчаар 2-оос доошгүй жил ажилласан байх, Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын зураг төсөл, техник тоноглолын чиглэлээр мэргэшсэн болон зөвлөх инженер бол гал түймрийн улсын хяналтын байцаагчаар ажилласан 1-ээс доошгүй жил ажилласан байх.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

4.1.Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн сул орон тоог шатлан дэвших зарчмын дагуу энэхүү журмын 3.5-д заасан шаардлагыг хангасан өндөр оноотой албан хаагчаас сонгон томилно.

4.2.Сонгон шалгаруулалтад оролцогч албан хаагч дараах шаардлагыг хангасан байна.

4.2.1.Зарласан албан тушаалын тодорхойлолт, тусгай шаардлагыг хангасан байх;

4.2.2.Сүүлийн 3 жил гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээ нь хангалтгүй үнэлгээ аваагүй байх;

4.2.3.Мэргэшүүлэх багц сургалтад бүрэн хамрагдаж, төгссөн байх; (Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэргэшүүлэх сургалт, Монголын зураг төсөл зохиогчдын холбооны мэргэшүүлэх багц сургалт хамаарна.)

4.2.4.Мэргэшүүлэх сургалтын агуулга, шалгуурыг Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх мэргэшүүлэх хөтөлбөрийн зөвлөлөөр батлуулна.

4.3.Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн нөөцөд бүртгэлтэй сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан албан хаагчаас дараах шалгалтыг авна.

4.3.1.Хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн тестийн шалгалт (35 оноо)

4.3.2.Галын аюулгүй байдлын стандарт, дүрэм, журам, норм нормативын тестийн шалгалт (35 оноо)

4.3.3.Монгол хэл, бичгийн чадвар (20 оноо)

4.3.4.Ярилцлага (10 оноо)

4.4.Шалгалтын комиссын гишүүд үнэлгээний үнэн зөв, бодитой байдлыг бүрэн хариуцна.

4.5.Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийг сургах, үнэлэх, мэргэшүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд Дотоод хэргийн их сургууль, Монголын зураг төсөл зохиогчдын холбоо болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

4.6.Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Тав. Шалгалтын комиссын ажил үүрэг

5.1.Шалгалт комиссыг /цаашид “комисс” гэх/-ыг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр Захиргаа, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн шийдвэрээр тухай бүр батлуулна.

5.2.Комисс нь зохион байгуулалт, үнэлгээ хийх, дүн мэдээлэх, гомдол шийдвэрлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.3.Цахим шалгалтын системийг үе шаттайгаар нэвтрүүлж, шалгалтын ил тод, нээлттэй байдлыг хангана.

Зургаа. Тайлан

6.1.Комисс шалгалтын үр дүнгийн дэлгэрэнгүй тайланг шалгалт дууссан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргаа, эрх зүй, хүний нөөцийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжид хүргүүлнэ.

6.2.Шалгалтын тайланд шалгалт зохион байгуулсан үйл явц, оролцогчдын ирц, үнэлгээний үр дүн, гарсан санал дүгнэлт зэргийг дэлгэрэнгүй тусгана.

Долоо. Хариуцлага

7.1.Шалгалтын үйл ажиллагаанд саад учруулсан, зохих журмыг зөрчсөн оролцогчийг шалгалтаас хасаж, хариуцлага тооцно.

7.2.Хуурамч баримт бүрдүүлсэн, худал мэдээлсэн оролцогчийн шалгалтыг үр дүнг хүчингүйд тооцно.

---oOo---